



2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ




Шинэ үнэт цаас болон ХК-ийн бүртгэл

2018 онд Монголын хөрөнгийн биржиг шинээр үнэт цаас бүртгүүлэхээр 9 компани хүсэлтээ ирүүлсэнийг судалж, нийт 5 компанийн 840,660,016 ширхэг үнэт цаасыг шинээр бүртгэж, 26.7 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.



Үнэт цаасны гавхар бүртгэл

Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны анхны гавхар бүртгэлийг нэвтрүүлж, Канад улсын Торонто хөрөнгийн биржиг бүртгэлтэй “Эргэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ийн 4,000,000 ширхэг үнэт цаасыг бүртгэж, дотоодын зах зээлээс 2.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.




Бүртгэлийн өөрчлөлт-Хувьцаа хуваах

“Хөвсгөл алтан дуулга” ХК болон “Товь” ХК-ууд нь тус тус биржиг бүртгэлтэй хувьцаагаа хувааж, бүртгүүлэхээр ирүүлсэн хүсэлтийг судалж, нийт бүртгэлтэй 7,914,411 ширхэг үнэт цаасыг 791,441,100 ширхэгт хуваан шинэчлэн бүртгэв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Бүртгэлийн өөрчлөлт – Нэмэлт үнэт цаас



Монголын хөрөнгийн биржиг бүртгэлтэй **3 ХК-ууд нэмэлт үнэт цаас гаргахаар хүсэлт** ирүүлсэнийг тус тус судалж, **2 ХК-ийн нэмж гаргасан 10,405,600 ширхэг үнэт цаасыг бүртгэн, нийт 4.8 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.**

Үүнд, **“Хөвсгөл алтан дуулга” ХК** – олон нийтээс **3.7 тэрбум төгрөг**, **“Хөтөлийн цемент шохой” ХК** – хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдаас **1.02 тэрбум төгрөг**, **“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК**-ийн нэмж гаргаж буй **158,306,416 ширхэг үнэт цаасыг бүртгэхээр зохих дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн.**

Бүртгэлтэй компанийн нэгдэл



Монголын хөрөнгийн биржиг **бүртгэлтэй 3 ХК-уудад** тус тус **нэгдэхээр 3 компани** хүсэлтээ ирүүлсэнийг судалж, зохих дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн ба үүнээс **“Баян-Алгар” ХК-г нэгдэх “Монгоруматриксгинко” ББСБ ХХК-ийн хүсэлт 2018 оны 12 дугаар сард зөвшөөрөгдснөөр түүний 19,922,679 ширхэг үнэт цаас бүртгэгдсэн.**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Биржийн бүртгэлээс хасах



2018 онд Монголын хөрөнгийн биржиг бүртгэлтэй гарах **9 ХК-уудыг бүртгэлээс хасахаар шийдвэрлэсэн**. Үүнд, “Баялаг налайх” ХК, “Усжуулах” ХК, “Зоос гоёл” ХК, “Монгол шир” ХК, “Аззан” ХК, “Дархан мах экспо” ХК, “Ажлын хувцас” ХК, “Бэрэн майнинг” ХК, “Эвлэл” ХК

Биржийн гишүүн ҮЦК



2018 онд Монголын хөрөнгийн биржиг шинээр **гишүүнээр элсэхээр 4 ҮЦК** хүсэлтээ ирүүлсэнийг судалж, холбогдох хууль, гурэм, журмын дагуу “Силвэр лайт секьюритиз ҮЦК”, “Централ секьюритиз ҮЦК” болон “Инвестор капитал ҮЦК” ХХК-уудыг биржийн гишүүнд элсүүлж, арилжаанд оролцох эрхийг олгосон. Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон “Би Би Эс Эс ҮЦК” болон “Товийн ноён нуруу ҮЦК” ХХК-уудыг биржийн гишүүнчлэлээс хассан.

Засгийн газрын үнэт цаас



Тайлант хугацаанд Сангийн яамнаас гомоогын зах зээлд Засгийн газрын үнэт цаас гаргахгүй байх төсөв, санхүүгийн бодлогыг баримталсантай холбоотой биржиг шинээр нэмж ЗГҮЦ-ыг бүртгээгүй буюу анхдагч зах зээлийн арилжаа огт хийгээгүй. Харин **319 тэрбум төгрөгийн эргэн төлөлт** хийгдэж **3,515,114 ширхэг ЗГҮЦ-ыг биржийн бүртгэлээс хассан**.

Журмын шинэчлэлтүүд

Арилжааны журам

“Арилжааны журам”-г хаалтын ханшийг илүү бодитой тогтоох зорилгоор сүүлийн нэг цагийн арилжааны жигнэсэн дунджаар ханшийг тогтоохоор тусгасан бөгөөд захиалгын шинэ төрлүүдийг игэвхижүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг, “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-г үнэ тогтоох, захилагын хуваарилалт хийх зарчмыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлсний зэрэгцээ бусад журмуудтай давхацсан зохицуулалтуудыг хасч, практик хэрэглээнд нийцүүлэн нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус оруулсан.



Үнэт цаасны бүртгэлийн журам

Үнэт цаасны давхар бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулж, бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын нийтлэг жишиг, практиктай нийцүүлсэн.



Үнэт цаасны үнийн индекс тооцох журам

ТОП-20 индексийн тооцооллын өөрчлөлт болон шинээр тооцох I ба II ангиллын самбар тус бүрт индексүүдийг тооцоолж эхэлсэн.

Гишүүнчлэлийн журам

МХБ-ийн гишүүн ҮЦК-уудад тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, гэрээний үүргийн хэрэгжилтэд тавигдах хяналтыг сайжруулсан.



НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН

IPO,
хоёрдогч
зах зээл
200

НИЙТ

1,000

800

600

400

200

хувьцаа
0

НИЙТ
859.1

НИЙТ
244.1
тэрбум төгрөгийн
арилжаа хийв.

НИЙТ
348.6

тэрбум төгрөгийн
арилжаа хийв.

ЗГҮЦ-ны арилжаа нь
нийт арилжааны 85.9%

тэрбум төгрөгийн
арилжаа хийв.
ЗГҮЦ-ны арилжаа нь
нийт арилжааны 89.9%

2018 онд ЗГҮЦ-ны
анхдагч зах
зээлийн арилжаа
огт хийгдээгүй
бөгөөд хоёрдогч
зах зээлийн
арилжаа нь нийт
арилжааны 14%.

160

120

80

40

2016 он

2017 он

2018 он

■ ЗГҮЦ-н хоёрдогч
зах зээлийн арилжаа

■ IPO

■ Хувьцааны хоёрдогч
зах зээлийн арилжаа

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

НИЙТ
772.5
тэрбум төгрөгийн
арилжаа хийв.

НИЙТ
299.6
тэрбум төгрөгийн
арилжаа хийв.

2018 онд ЗГҮЦ-ны анхдагч зах
зээлийн арилжаа огт
хийгдээгүй бөгөөд хоёрдогч зах
зээлийн арилжааны дүн 33.5
тэрбум төгрөгт хүрч буурсан.

630.2
тэрбум

142.3
тэрбум

НИЙТ
33.5
тэрбум төгрөгийн
арилжаа хийв.

2016 он


2017 он

2018 он

■ ЗГҮЦ-ны анхдагч
зах зээлийн арилжаа

■ ЗГҮЦ-ны хоёрдогч
зах зээлийн арилжаа

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА






■ IPO, FPO

■ Хоёрдогч зах зээлийн арилжаа

АНХНЫ ДАВХАР БҮРТГЭЛ



MSE:ERDN

TSX:ERD

Татан төвлөрүүлсэн хөрөнгө:	
	2,5 тэрбум төгрөг
Бүртгэгдсэн үнэт цаасны тоо ширхэг:	
	3,89 сая ширхэг
Нийтэд санал болгох үнэ:	
	640 төгрөг
МХБ-д гаргасан хувьцааны хувь:	
	2,7%

Канадын Торонто хөрөнгийн биржиг бүртгэлтэй "Эргэнэ ресурс девелопмент корпорэйшн" нь Монголын хөрөнгийн биржийн хамгийн анхны давхар бүртгэлтэй компани болсон бөгөөд олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 1,248 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтгээ 6,478,146 ширхэг хугалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон гүнг гаруй 66 хувиар давсан үзүүлэлт болсон.

ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХИЖИЛТ

2018 онд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээс “Лэндмн” ХК-ийн хувьд 16.5 дахин их, “Монголбазальт” ХК-ийн хувьд 3 дахин их, “Эрдэнэ ресурс” ХК-ийн хувьд 1.6 дахин их, “Мандал даатгал” ХК-ийн хувьд 1.2 дахин их, “Ард даатгал” ХК-ийн хувьд 1.3 дахин их тус тус давсан үзүүлэлт нь хөрөнгийн зах зээлд сонирхогч болон оролцогчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхижсэнийг харуулж байна.




КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР


“Сүү Бонд” нь 2017 оны 06 дугаар сарын 29-ны анхдагч зах зээлээс **6 тэрбум** төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь МХБ-ийн түүхэн дэх хамгийн өндөр дунтэй компанийн өрийн хэрэгсэл болсон. 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдөр Сүү бондын эргэн төлөлт амжилттай хийгдэж, **бондын хүүнг 1.05 тэрбум төгрөгийг нийт 110 хөрөнгө оруулагчдад төлсөн.**





ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСУУД


ТОП-20



"ТОП-20" ИНДЕКСИЙН САГСЫГ ЖИЛД НЭГ УДАА ШИНЭЧИЛДЭГ БӨГӨӨД 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ӨНГӨРСӨН ОНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР САГСЫГ ШИНЭЧЛЭХЭД ӨМНӨХ САГСАД БАГТАЖ БАЙСАН 18 КОМПАНИ ХЭВЭЭР ҮЛДЭЖ, "БАГАНУУР", "ЖЕНКО ТҮР БҮРО" ХК-ИУД ХАСАГДАЖ, ШИНЭЭР "МИК", "ШИВЭЭ ОВОО" ХК-ИУД НЭМЭГДЭВ.


САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МХБ ТӨХК нь 2018 онд үйл ажиллагаанаас нийт **1.8 тэрбум** төгрөгийн орлогыг олж, 1.4 тэрбум төгрөгийн зардал гаргаснаар нийт **468.8 сая** төгрөгийн цэвэр орлоготой ажилласан ба МIТ цогц системийн ашиглалтын зардал болон элэгдэл, хорогдолд нийт **1.2 тэрбум** төгрөгийн зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайлангаа татварын өмнөх байглаар **805.1 сая** төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөд байна.



НИЙТ ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2018 онд нийт **хувьцааны арилжааны** дүн өмнөх оноос **2.7 дахин нэмэгдсэн** боловч **ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа** огт хийгдээгүй нь үйл ажиллагааны нийт орлогыг 1.8 тэрбум төгрөгт хүргэж өмнөх оноос буурахад нөлөөлжээ.



■ Уйл ажиллагааны нийт орлого


■ Хураамж, үйлчилгээний хөлс

■ Арилжааны шимтгэлийн орлого (Хувьцаа, Бонг)

■ Бусад орлого

НИЙТ ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МХБ ТӨХК нь хөрөнгийн зах зээлийн гэгэ бүтэц болох MIT системийн ашиглалт, элэгдэл хорогдлын зардлыг **гангаар хариуцдаг** бөгөөд үүнтэй холбоотой **2018 онд 1.2 тэрбум** төгрөгийн зардлыг санхүүгийн тайлангаа хүлээн зөвшөөрсөн нь ийнхүү алдагдалтай ажиллахад хүргэжээ. Цаашиг MIT системийн ашиглалт, элэгдэл хорогдлын зардлыг системийг ашиглагч гэгэ бүтцийн байгууллагуудтай хувааж, хариуцах талаар холбогдох ажлыг эхлүүлээд байна. MIT системийн “Үйл ажиллагааны гэмжлэг үзүүлэх гэрээ”-г 2018 онд сунгасантай холбоотой гэрээний 2017 оны 3-р сараас 12-р сарын төлбөрүүдийг нөхөж хуримтлуулсан болно.



■ Нийт зардал

■ Цалин, НДШ-ийн зардал

■ Үйл ажиллагааны бусад зардал

■ MIT ашиглалтын зардал




ДЭД БҮТЦИЙН АЮУЛГҮЙ, ХЭВИЙН АЖИЛЛАГАА

МХБ ТӨХК нь Улсын төсвөөс ямар нэгэн санхүүжилт авалгүйгээр, хөрөнгийн зах зээлийн гэгэ бүтцийн аюулгүй, найгвартай, хэвийн ажиллагааг хангахад зориулж, **нийт 838.9 сая төгрөгийн төлбөрийг компанийн өөрийн мөнгөн эх үүсвэрээс төлж барагдуулсан** байна. Үүнд:

- ❖ Лондонгийн хөрөнгийн бирж групптэй байгуулсан "Ажлын мастер гэрээ"-ний гэгэ гэрээ болох MIT системийн "Үйл ажиллагааны гэмжлэг үзүүлэх гэрээ"-г 2018 онд 2 жилээр сунгасан.
- ❖ Компанийн хувьцаа эзэмшигч (Сангийн яам)-с өгсөн чиглэлийн хүрээнд "Ажлын мастер гэрээ"-ний төлбөрийг **Монгол Улсын төсвөөс санхүүжүүлэхийг зогсоосон** бөгөөд компанийн **үйл ажиллагааны орлогоос** гэрээний 2017 оны төлбөрт **156,897 ам.долларыг** Лондонгийн хөрөнгийн бирж группд төлж барагдуулсан ба түүнд ногдох НӨАТ-аг болох **38.2 сая төгрөгийг** Монгол Улсын төсөвт төлж, шилжүүлсэн.
- ❖ Тайлант жилд зах зээлийн гэгэ бүтцийн өгөгдлийн сангийн аюулгүй, найгвартай, хэвийн ажиллагааг хангаж, 2013 онд хугацаа нь дууссан байсан **"ORACLE"** лицензийг шинээр худалдан авахад **422.7 сая төгрөгийг** компанийн **үйл ажиллагааны орлогоос** зарцуулсан.

УЛСЫН ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР, ШИМТГЭЛ

МХБ ТӨХК нь 2018 онд Улсын төсөвт нийт **362.4 сая** төгрөгийн татвар, хураамж, шимтгэлийг төлсөн.





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК

Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот, Монгол Улс

Факс: (976)-11-325 170

Веб хуудас: www.MSE.mn